

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
ДМАЭМБ	Мал эмнэлгийн үйлчилгээний гүйцэтгэлийн үнэлгээ

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3.Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8. Аудитын илрүүлэлт.....	11
Залруулсан алдаа.....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	12
Аудитын зөвлөмж.....	12
3.9. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	12
4. Менежментийн захидал	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МАЛ АЖ АХУЙН ЭДИЙН ЗАСГИЙН
ЭРГЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ
Т.ЖАМБАЛЦЭРЭН ТАНАА

2021.02.25 № 08/536
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга илэрхийлсэн толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Төслийн удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Төслийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 бүрэлдэхүүн хэсгийн нийт 17 хийгдэх ажил төлөвлөснөөс 87 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	6,633,631,708.03
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,111,807,708.03
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,111,807,708.03
31210	Төгрөг	-	53,478,207.61
31211	Төрийн сангийн харилцах	-	53,478,207.61
31220	Гадаад валют	-	2,058,329,500.42
31223	Арилжааны банк дахь харилцах	-	2,058,329,500.42
34	УРЬДЧИЛГАА	-	4,521,824,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	4,521,824,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	264,872,134.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	264,872,134.60
39200	Биет хөрөнгө	-	264,872,134.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	209,750,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	-	60,308,962.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(5,186,827.40)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	6,898,503,842.63
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	6,898,503,842.63
51	Засгийн газрын хувь оролцоо	-	6,898,503,842.63
51200	Хуримтлагдсан үр дүн	-	6,898,503,842.63
51220	Тайлант үеийн үр дүн	-	6,898,503,842.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	6,898,503,842.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	7,366,404,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	7,366,404,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	7,366,404,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	7,366,404,000.00
200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	7,366,404,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	463,920,520.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	463,920,520.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	463,920,520.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	294,832,116.88
210101	Үндсэн цалин	-	294,832,116.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	29,918,728.89
210201	Тэтгэврийн даатгал	-	29,918,728.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	54,356,000.00
210304	Байрны түрээс	-	54,356,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	18,407,629.88
210401	Бичиг хэрэг	-	4,852,660.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,937,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,242,389.88
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	6,375,530.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,605,000.00
210702	Дотоод албан томилолт	-	1,605,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	59,314,217.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	59,218,880.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	95,337.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,486,827.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	300,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	5,186,827.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-	6,902,483,479.55
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	7,630,064.32
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	7,630,064.32
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	11,609,701.24
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	4,433,701.24
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	-	7,176,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-	6,898,503,842.63

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	-	2,844,580,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,844,580,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,844,580,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	2,844,580,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	2,844,580,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	458,733,693.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	458,733,693.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	458,733,693.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	294,832,116.88
210101	Үндсэн цалин	-	294,832,116.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	29,918,728.89
210201	Тэтгэврийн даатгал	-	29,918,728.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	54,356,000.00
210304	Байрны түрээс	-	54,356,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	18,407,629.88
210401	Бичиг хэрэг	-	4,852,660.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,937,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,242,389.88
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	6,375,530.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,605,000.00
210702	Дотоод албан томилолт	-	1,605,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	59,314,217.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	59,314,217.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	300,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	2,385,846,306.95
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	277,234,962.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	277,234,962.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	277,234,962.00
222001	Тоног төхөөрөмж	-	7,176,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	270,058,962.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(277,234,962.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	3,196,363.08
14	Бусад эх үүсвэр	-	7,630,064.32
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	7,630,064.32
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	4,433,701.24
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	4,433,701.24
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	2,111,807,708.03
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,111,807,708.03

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	6,898,503,842.63	6,898,503,842.63
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	6,898,503,842.63	6,898,503,842.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/				
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,767,344,800.00	5,257,792,655.05	509,552,144.95	91.2
УРСГАЛ ЗАРДАЛ	5,128,195,800.00	4,980,557,693.05	147,638,106.95	97.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,128,195,800.00	4,980,557,693.05	147,638,106.95	97.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	301,653,600.00	294,832,116.88	6,821,483.12	97.7
Үндсэн цалин	301,653,600.00	294,832,116.88	6,821,483.12	97.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,771,400.00	29,918,728.89	852,671.11	97.2
Тэтгэврийн даатгал	30,771,400.00	29,918,728.89	852,671.11	97.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,256,000.00	54,356,000.00	900,000.00	98.4
Байрны түрээс	55,256,000.00	54,356,000.00	900,000.00	98.4
Хангамж, бараа материалын зардал	38,130,500.00	18,407,629.88	19,722,870.12	48.3
Бичиг хэрэг	4,865,700.00	4,852,660.00	13,040.00	99.7
Тээвэр, шатахуун	3,946,800.00	3,937,050.00	9,750.00	99.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,159,700.00	3,242,389.88	917,310.12	77.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,158,300.00	6,375,530.00	18,782,770.00	25.3
Томилолт, зочны зардал	1,605,000.00	1,605,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	1,605,000.00	1,605,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,700,479,300.00	4,581,138,217.40	119,341,082.60	97.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,700,479,300.00	4,581,138,217.40	119,341,082.60	97.5
Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	300,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	300,000.00	-	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	639,149,000.00	277,234,962.00	361,914,038.00	43.4
Тоног төхөөрөмж	639,149,000.00	277,234,962.00	361,914,038.00	43.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,767,344,800.00	7,366,404,000.00	(1,599,059,200.00)	127.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,767,344,800.00	7,366,404,000.00	(1,599,059,200.00)	127.7
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,767,344,800.00	7,366,404,000.00	(1,599,059,200.00)	127.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,111,807,708.03		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Т.Жамбалцэрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд э-баримтыг анхан шатны баримтад бүрэн хавсаргах, дотоод хяналтын сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 1 дүгээр сарын 25-наас 2021 оны 2 дугаар сарын 25-ны хооронд “Грант Торнтон аудит” ХХК-ийн захирал Ерөнхий захирал, Удирдах партнер Б.Осоргарав, чанарын хянагч Н.Эрдэнэцог, гэрээт ажлын менежер Б.Дэлгэрмаа нар хянан удирдаж, аудитор Б.Эрдэнэбат, туслах аудитор Э.Удвал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр цахимаар ирүүлж, эх хувийг 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 57/01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн зорилгыг “Малын эрүүл мэнд, үр ашиг, бүтээмж болон төсөл хэрэгжих газрууд дахь нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл нь доорх 4 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Малын эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэх;
- Нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх;
- Төслийн хэрэгжилтийг дэмжих;
- Байгалийн гамшиг, онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл нь тайлант онд дараах онцлох ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Нэгдсэн үндэсний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтарч, үндэсний болон бүсийн лавлагаа лабораториудад үнэлгээ хийх, эмнэлгийн салбарын боловсролын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, чадавхыг бэхжүүлэх ажлыг эхлүүлсэн байна.
- Мал эмнэлгийн тандалтын тогтолцоонд үнэлгээ хийх үндэсний зөвлөхийг сонгон шалгаруулжээ.
- Төслийн хүрээнд 2020-2025 он хүртэл 20 чиглэлээр, 3105 ашиг хүртэгчийг сургалтад хамруулах төлөвлөгөө боловсруулсан байна.
- Төслийн суурь судалгаа, хөндлөнгийн үнэлгээ хийх Эс Ай Си Эй ХХК-тай гэрээ байгуулсан байна.

- Төслийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод явуулах, сурталчлах зорилгоор веб хуудас бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн санхүүгийн үйл ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас дотоод аудит хийгдээгүй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төсөл нь гадаадын зээлээр хэрэгждэг тул материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зээлийн зарцуулалтад үндэслэн 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,997,354.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 49,973.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл нь 2020 оны 6 дугаар сарын 07-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 6,898,503.8 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэй тайлагнагдсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	2,111,807.7	2,111,807.7
Урьдчилгаа	-	4,521,824.0	4,521,824.0
Үндсэн хөрөнгө	-	264,872.1	264,872.1
Нийт хөрөнгө	-	6,898,503.8	6,898,503.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	-	6,898,503.8	6,898,503.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	6,898,503.8	6,898,503.8

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд Дэлхийн банкнаас санхүүжилтийн гэрээний урьдчилгаа төлбөрт 2,844,580.0 мянган төгрөг олгосноос төслийн үйл ажиллагаа жигдрээгүйгээс шалтгаалж 2,111,807.7 мянган төгрөгийг зарцуулаагүй байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Дэлхийн банкнаас техникийн туслалцаа болон худалдан авалтын зөвлөх багт 4,521,824.0 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрийг гэрээний дагуу шилжүүлснийг бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өртөгт 209,750.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 60,309.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж нийт 270,029.0 мянган төгрөгийн худалдан авсан хөрөнгийг бүртгэсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,000,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс нийт зарлагыг 3,767,344.8 мянган төгрөгөөр Сангийн яамнаас нэмэгдүүлэн 5,767,344.8 мянган төгрөгөөр баталсан нь техникийн туслалцаа болон худалдан авалтын зөвлөх багийн урьдчилгаа төлбөрийг авч, шилжүүлэхтэй холбоотой тооцооллыг нэмж оруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөлд 5,767,344.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 7,366,404.0 мянган төгрөгийн санхүүжилт авчээ. Төлөвлөснөөс 1,599,059.2 мянган төгрөгөөр илүү санхүүжилт олгосон нь техникийн туслалцаа болон худалдан авалтын зөвлөх багийн санхүүжилтийг нэмж олгосонтой холбоотой байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэл 5,257,792.7 мянган төгрөг буюу 91 хувьтай байгаа нь хөрөнгийн зардлыг 361,914.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 119,341.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь "Шилэн дансны тухай" хуулийн 6 дугаар зүйлд заасан 19 төрлийн 82 мэдээллээс 44 мэдээллийг хугацаандаа байршуулж, 38 мэдээллийг хугацаа хоцорч шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,530,360.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,521,824.0 мянган төгрөгийн алдааг залруулж, шилэн данстай холбоотой зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 8,536.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. UTF/MON/021/MON тоот гэрээний дагуу төлсөн 4,521,824.0 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрийг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэснийг Урьдчилгаа дансанд залруулга хийлгэв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар дараах зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл нь шилэн дансны 19 төрлийн 82 мэдээллүүдээс 44 мэдээллийг хугацаа хоцроон тайлагнасан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 8,536.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.9. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд нийт 5,750.0 мянган төгрөгийн худалдан авалтад э-баримт аваагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.3.2-д "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

1.2. Эрсдэл:

Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд нь санхүүгийн болон татварын тайландаа орлого тусгахгүй байх, нуун дарагдуулах, Зөрчлийн тухай хуулийн дагуу торгууль тавигдах, Дэлхийн банкны баталсан төслийн зарцуулалтын гарын авлагад заасны дагуу нотлогдоогүй зардлыг нөхөн төлөх;

1.3. Өгсөн зөвлөмж:

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу баримтыг бүрэн бүрдүүлж, баримтын бүрдэл хангасан ажил гүйлгээг бүртгэлд тусгаж байх;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Борлуулагч байгууллагуудтай цахимаар холбогдож э-баримтаа нөхөн шивэх, эс бөгөөс хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэхийг анхааруулсны үндсэнд аудитын хугацаанд буюу 2021 онд цахим системд шивүүлсэн.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Ажилтнуудын 7-р сарын цалинг тооцохдоо баталгаажсан цагийн бүртгэлийг үндэслээгүйн улмаас 2,786.6 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйл 14.3 "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг гүйцэтгэх дараалал"-тай нийцээгүй байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, дотоод хяналт хангалтгүй байх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг анхан шатны баталгаажсан баримтад үндэслэн, үнэн зөв гүйцэтгэж байх;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цалингийн гүйлгээг хийхдээ төлбөрийн баримт, цалингийн тооцоолол, цагийн бүртгэлийг Төрийн санд хүргүүлж, хянуулан төлбөр хийгддэг. 7-р сард цагийн бүртгэл Төрийн санд орсон хойгуур ажилтнууд маань ажилласан боловч цагийн бүртгэлээ бөглөөгүй дутуу үлдээсэн нь тэр чигтэй архивт орсон байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2021/110/79-ТХН САГ-
Шалгагдсан байгууллагын нэр:	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	UTF/MON/021/MON тоот гэрээний урьдчилгаанд төлсөн 4,521,824.0 мянган төгрөгийг тайланд тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	4,521,824.0	Залруулах.	Нягтлан бодогч	Ж.Сүхгэрэл
2	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл нь шилэн дансны 19 төрлийн 82 мэдээллүүдээс 44 мэдээллийг хугацаа хоцроон тайлагнасан.	-	Албан шаардлага.	Төслийн зохицуулагч, Нягтлан бодогч	Ц.Ванчин, Ж.Сүхгэрэл
3	Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн тайлант хугацааны худалдан авалтыг анхан шатны баримт руу хөөн шалгахад 5,750.0 мянган төгрөгийн э-баримтыг борлуулагч байгууллагуудаас шаардаж, анхан шатны баримтандаа хавсаргаагүй байна.	5,750.0	Зөвлөмж өгөх.	Нягтлан бодогч	Ж.Сүхгэрэл
4	ТХН-ийн ажилтнуудын 7-р сарын цалинг тооцохдоо холбогдох анхан шатны баримт болох баталгаажсан цагийн бүртгэлийг үндэслээгүй байна.	2,786.56	Зөвлөмж өгөх.	Төслийн зохицуулагч, Нягтлан бодогч	Ц.Ванчин, Ж.Сүхгэрэл
ДҮН		4,530,360.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 160/АД/60063

Улаанбаатар хот

САГ-2021/110/79-ТХН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь шилэн дансны цахим хуудсанд байршуулах нийт 19 төрлийн 82 мэдээллээс 44 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.4.1 "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг байгууллагын шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь, үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн зохицуулагч Ц.Ванчин, санхүүгийн ажилтан Ж.Сүхгэрэл нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.ЭРДЭНЭЗУЛ

Б.ЭРДЭНЭБАТ

[illegible]

[illegible]

[illegible]